



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

416. Элчин сайдыг эгүүлэн татах,  
томилох тухай Дугаар 101 1653

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

417. Шалгуур, үзүүлэлт батлах тухай Дугаар 57 1653

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 06 дугаар  
сарын 13-ны өдөр Дугаар 101 Улаанбаатар  
хот

#### Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Чили Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Пэрэнлэй овогтой Үржинлхүндэвийг эгүүлэн татах, Монгол Улсаас Бүгд Найрамдах Чили Улсад суух Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайдаар Отгонбаяр овогтой Даваасамбууг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ** Ц.ЭЛБЭГДОРЖ

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 1 дүгээр  
сарын 30-ны өдөр Дугаар 23 Улаанбаатар  
хот

#### Шалгуур, үзүүлэлт батлах тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5<sup>4</sup>.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

- Хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтийг хавсралт ёсоор баталсугай.

2. Шалгуур, үзүүлэлтийг үндэслэн эрсдэлийн ангилалд хамаарах объектын жагсаалт, шалгалтад хамруулах давтамжийн хугацааг хяналтын чиглэлбүрээр баталж, мөрдүүлэхийг Монгол Улсын Шадар сайд М.Энхболдод даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД**

**М.ЭНХБОЛД**

Засгийн газрын 2012 оны 23 дугаар  
тогтоолын хавсралт

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ОБЪЕКТЫГ ЭРСДЭЛИЙН  
АНГИЛАЛД ХАМААРУУЛАХ ШАЛГУУР, ҮЗҮҮЛЭЛТ**

№	Чиглэл	Эрсдэлийн шалгуур, үзүүлэлтийн нэр, код
1	Хүнсний аюулгүй байдал	1.1.Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
2		1.2.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
3		1.3.Хүнсний худалдаа, үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
4		1.4.Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
5		1.5.Ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
6		1.6.Импортын бүтээгдэхүүнийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
7	Байгаль орчин	2.1.Байгаль орчны хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
8		2.2.Уул уурхайн хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
9		2.3.Геологийн хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
10	Эрүүл мэнд	3.1.Эрүүл мэндийн байгууллагыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
11		3.2.Ундны усны чанар, аюулгүй байдлын эрсдэлийг үнэлэх шалгуур, үзүүлэлт
12		3.3.Эрүүл ахуй халдварт судлалын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
13	Эм, био бэлдмэл	3.4.Эмийн худалдаа, үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
14		3.5.Эм үйлдвэрлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт



15	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	4.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
16	Нийгмийн хамгаалал	4.2.Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн харилцааны хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
17	Барилгын техник	5.1.Барилга, байгууламжийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
18		5.2.Барилгын материал үйлдвэрлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
19	Авто зам	5.3.Авто зам, замын байгууламж, онгоц хөөрч буух зурвасыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
20		5.4.Эрчим хүч (цахилгаан, дулаан)-ний хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
21	Эрчим хүч	5.5.Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, шингэрүүлсэн шатдаг хийг хадгалах, түгээх байгууламжийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
22	Өргөх механизм	5.6.Өргөх байгууламж үйлдвэрлэдэг, ашигладаг байгууллагыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
23	Тээвэр	5.7.Тээврийн үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
24	Мэдээлэл холбоо	5.8.Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
25	Хэмжил зүй	5.9.Хэмжүүр, хэмжих хэрэгсэл ашигладаг байгууллагыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
26	Боловсрол	6.1.Боловсролын байгууллагыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
27	Соёл	6.2.Соёлын өв хадгалдаг байгууллагыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
28		6.3.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт
29	Санхүү	7.1.Санхүүгийн хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

### 1.1. ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭГЧ ЭТГЭЭДИЙГ ЭРСДЭЛИЙН АНГИЛАЛД ХАМААРУУЛАХ ШАЛГУУР, ҮЗҮҮЛЭЛТ

	Шалгуур	Оноо
Нэг. Үйлдвэрлэдэг бүтээгдэхүүний төрөл, боловсруулалтын байдал:		
1.1	Мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн (мах, сүү, загас, өндөг, нөөшилсөн загас), хагас боловсруулсан бүтээгдэхүүн (бууз, баш, хуушуур, котлет гэх мэт), мал, амьтны болон ургамлын гаралтай дахин боловсруулалтгүйээр шууд хэрэглэх хүнс (терөл бүрийн хиам, зайдас, нухаш, утсан загас, мах, дулааны боловсруулалт хийгээгүй жимс, ногооны шүүс гэх мэт) майонез болон түүгээр хийсэн төрөл бүрийн сүмстий ногооны салат, пицца, пирожки, мах, бяслаг хавчуулсан хачирттай талх, өтгөрүүлсэн, хуурай сүү, төрөл бүрийн зайдраг, өндер хэмд болгоогүй кремтэй гурилан бүтээгдэхүүн (бялуу, жигнэмэг, нарийн боов)	10
1.2	Шоколад, какаогоор хийсэн төрөл бүрийн хатуу, зөвлөн чихэр, үрэл, дулааны боловсруулалт хийсэн жимсний чанамал, компот, жимсний шүүс, даршилсан хүнсний ногоо, зэгийн бал	5

1.3	Үр тариа, гурил, будаа, талх, төрөл бүрийн шанз, кремгүй жигнэмэг, бусад гурилан бүтээгдэхүүн, архи, спирт, дарс, шар айраг, хийжүүлсэн ундаа, төрөл бүрийн ундаа (савалсан ус, раашан)	1
Хоёр. Онцгой бүлэгт зориулсан хүнс:		
2.1	Нялхас болон бага насын хүүхдийн хоол тэжээл, хоолны онцгой дэглэмтэй хүмүүс, эмнэлэг, сувилалд хэвтэн эмчлүүлж байгаа хүмүүст зориулсан хоол хүнс	10
Гурав. Үйлдвэрлэлийн хоногийн хүчин чадал:		
3.1	8 тонноос илуу бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг	10
3.2	1.1-8 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг	5
3.3	1 тонноос бага хэмжээтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг	1
Дөрөв. Үйлдвэрлэлийн ажлын байрны нөхцөл:		
4.1	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулах байр нь зориулалтын бус, технологийн урсгал буруу, түүхий эд хадгалах, бэлтгэх, боловсруулах болон ажиллагдын хувцас солих өрөө, тасалгаагүй (Хяналтын хуудасны "Үйлдвэрийн гаднах орчин, барилга байгууламж" хэсгийн асуултуудын 50 хувьд хангалтгүй гэж үнэлгэдсэн)	10
4.2	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулах байр нь зориулалтын бус, засвар үйлчилгээ хийж өөрчилсөн, түүхий эд хадгалах, бэлтгэх, боловсруулалт хийх болон ажиллагдын хувцас солих өрөө, тасалгааг зохион байгуулсан боловч шаардлага хангаагүй (Хяналтын хуудасны "Үйлдвэрийн гаднах орчин, барилга байгууламж" хэсгийн асуултуудын 51-70 хувьд хангалттай хийж үнэлгэдсэн)	5
4.3	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулах байр нь зориулалтын, технологийн урсгал зөв, боловсруулалт хийх, бэлтгэх өрөө, түүхий эд хадгалах агуулах, ажиллагдын хувцас солих өрөө, тасалгааг шаардлагын дагуу тусад нь зохион байгуулсан (Хяналтын хуудасны "Үйлдвэрийн гаднах орчин, барилга байгууламж" хэсгийн асуултуудын 71-ээс дээш хувьд хангалттай хийж үнэлгэдсэн)	1
Тав. Хадгалалтын горимын мөрдөлт хангагдах нөхцөл:		
5.1	Түүхий эд, бэлэн бүтээгдэхүүн, сав, баглаа, боодлыг тусгаарлан хадгалах нөхцөл, горимын дагуу хадгалдаггүй (ил задгай, эсхүл хадгалах өрөө, агуулахын хэм, чийглэгийг тохишуулж хадгалах боломжгүй, хэм, чийглэгийг хэмждэггүй, амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, зах зээлээс эргүүлэн татсан, хаяг, шошголот хийж баталгаажуулаагүй бүтээгдэхүүн болон угаалга, ариутгал, цэвэрлэгээний бодистой хамт хадгалдаг)	10
5.2	Түүхий эд, бэлэн бүтээгдэхүүн, сав, баглаа, боодлыг тусгаарлан хадгалах өрөө, тасалгааны хүрэлцээ хангалтгүй, түүхий эд, бэлэн бүтээгдэхүүнийг горимын дагуу хадгалдаг боловч хэмийг хэмжих багаж төхөөрөмжгүй	5
5.3	Түүхий эд, бэлэн бүтээгдэхүүн, сав, баглаа, боодлыг зохих хэмд тусгаарлан хадгалах өрөө, тасалгаатай, хөргөлтийн тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан, хэм, чийглэгийг хэмжиж тэмдэглэдэг	1
Зургаа. Ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл:		
6.1	Ариутгал, халдвартгүйтгэл, цэвэрлэгээ хийгдэггүй, шавьж, мэрэгч амьтан үүрлэх нөхцөл бүрдсэн	10
6.2	Ариутгал, халдвартгүйтгэл, цэвэрлэгээ тогтмол хийгдэггүй, шавьж, мэрэгч амьтан үүрлэх нөхцөлөөс хамгаалсан боловч хяналт тавьдаггүй	5
6.3	Ариутгал, халдвартгүйтгэлийг мэргэжлийн байгууллагаар гэрээгээр тогтмол хийлгэдэг, эсхүл тухайн байгууллага зааврын дагуу устгалыг хийдэг, шавьж, мэрэгч амьтан үүрлэх нөхцөлөөс бүрэн хамгаалсан	1



Долоо. Усан хангамжийн нөхцөл:	
7.1	Усан хангамж нь тодорхой бус, зөөврийн усан хангамжтай, усаа нөөцлөн хэрэглэдэг, усны эрүүл ахуй, аюулгүй байдал (хлорын агууламж, эмгэг төрөгч бичил биетэн гэх мэт)-д шинжилгээ хийлгэдэггүй
7.2	Худгаас шугам, хоолойгоор дамжуулан нөөцлөхгүйгээр үйлдвэрлэлд шууд хэрэглэдэг, усны эрүүл ахуй, аюулгүй байдалд шинжилгээ хийлгэдэггүй
7.3	Төвлөрсөн усан хангамжтай, усны эрүүл ахуй, аюулгүй байдалд шинжилгээ хийлгэдэггүй
7.4	Худгаас шугам, хоолойгоор дамжуулан нөөцлөхгүйгээр үйлдвэрлэлд шууд хэрэглэдэг усны эрүүл ахуй, аюулгүй байдалд шинжилгээ хийлгэдэг
7.5	Төвлөрсөн усан хангамжтай, усны эрүүл ахуй, аюулгүй байдалд шинжилгээ хийлгэдэг
Найм. Бохир ус зайлцуулах нөхцөл:	
8.1	Бохир ус зайлцуулах шугам сүлжээ байхгүй
8.2	Бохир ус зайлцуулах хэсгийн шугамд холбогдсон бохирыг тогтмол хугацаанд соруулж зайлцуулдаг
8.3	Төвлөрсөн бохир ус зайлцуулах шугамд холбогдсон
Ес. Хатуу хог хаягдлын нөхцөл:	
9.1	Хог хаягдлын цэг нь шаардлага хангаагүй
9.2	Хог хаягдлыг тогтмол ачуулдаггүй
9.3	Шаардлага хангасан хог хаягдлын цэгтэй
Арав. Хүнсний гаралтай хордлого, халдварт өвчин гарсан байдал:	
10.1	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс нь олныг хамарсан хүнсний гаралтай хордлого (үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн нь хордлого, халдварт өвчин үүсгэгч бичил биетнээр бохирдсон), халдварт өвчин давтан гарсан
10.2	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс нь олныг хамарсан хүнсний гаралтай хордлого, халдварт өвчин гарсан, бүтээгдэхүүн нь өвчин үүсгэгч бичил биетнээр бохирдсон шалтгааныг тодорхойлж арга хэмжээ авдаг
10.3	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс хүнсний гаралтай хордлого, халдварт өвчин гарч байгаагүй, хүнсний гаралтай хордлого, халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж ажилладаг
Арван ногт. Өмнө хийсэн хяналт шалгалтын талаархи мэдээлэл:	
11.1	Хууль тогтоомжийг ноцтой зөрчсөний улмаас их хэмжээний торгуулийн арга хэмжээ авагдаж байсан, өмнө хийсэн шалгалтын дунд илэрсэн зөрчил давтан гардаг, үйл ажиллагааг нь түр хугацаагаар зогсоож байсан
11.2	Хууль тогтоомжийг биелүүлж ажиллаагүйн улмаас торгуулийн арга хэмжээ авагдаж байсан, улсын байцаагчийн өгсөн албан шаардлагыг дуттуу биелүүлдэг
11.3	Хууль тогтоомж болон улсын байцаагчийн өгсөн албан шаардлагыг биелүүлж ажилладаг
Арван хоёр. Ажиллагсдын эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдсан байдал:	
12.1	Ажиллагсдыг (шинэ ажилд орсон) эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, халдварт, паразит өвчлөлийн шинжилгээнд огт хамруулагдаггүй
12.2	Ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, халдварт, паразит өвчлөлийн шинжилгээнд анх ажилд орсноос хойш дахин давтан хамруулаагүй



12.3	Ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, халдварт, паразит өвчлөлийн шинжилгээнд 6 сар тутам хамруулдаг, ажиллагсдын эрүүл мэндийн байдалд өдөр тутам хяналт тавьдаг	1
Арван гурав. Ариун цэвэр, эрүүл ахуйн сургалт явуулдаг байдал:		
13.1	Ажиллагсдыг эрүүл ахуйн зохистой дадал (гар угааж, халдвартгүйтгэх, угаалга, цэвэрлэгээ, армутгал хийх гэх мэт) хэвшүүлэх чиглэлээр сургалтад хамруулдаггүй, байгууллага дотроо эрүүл ахуйн зохистой дадал хэвшүүлэх сургалт тогтмол зохион байгуулдаггүй	10
13.2	Ажиллагсдыг эрүүл ахуйн зохистой дадал хэвшүүлэх чиглэлээр сургалтад тогтмол хамруулдаггүй, байгууллага дотроо эрүүл ахуйн зохистой дадал хэвшүүлэх сургалт тогтмол зохион байгуулдаггүй	5
13.3	Ажиллагсдыг эрүүл ахуйн зохистой дадал хэвшүүлэх чиглэлээр сургалтад бүрэн хамруулдаг, байгууллага дотроо эрүүл ахуйн зохистой дадал хэвшүүлэх сургалтыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулдаг	1

52-130 оноо авсан хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг этгээд-Их эрсдэлтэй (эрсдэл ихтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага, хууль тогтоомж, дүрэм, журамд тогтоогдсон шалгуур, үзүүлэлт, шаардлагуудыг зөрчсөн)

30-51 оноо авсан хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг этгээд-Дунд эрсдэлтэй (ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага, хууль тогтоомж, дүрэм, журамд тогтоогдсон шалгуур, үзүүлэлт, шаардлагуудыг зөрчсөн)

30-аас бага оноо авсан хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг этгээд-Бага эрсдэлтэй (үйлдвэрийн цар хэмжээ бага, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага, хууль тогтоомж, дүрэм, журамд тогтоогдсон шалгуур, үзүүлэлт, шаардлагуудыг зөрчөөгүй)

## 1.2. ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ ЭТГЭЭДИЙГ ЭРСДЭЛИЙН АНГИЛАЛД ХАМААРУУЛАХ ШАЛГУУР, ҮЗҮҮЛЭЛТ

Шалгур		Оноо
Нэг. Хоногт үйлдвэрлэж буй нийт хоолны тоо порцоор:		
1.1	501-ээс дээш порц хоол үйлдвэрлэж, үйлчилдэг	10
1.2	51-500 порц хоол үйлдвэрлэж, үйлчилдэг	5
1.3	50-иас доош порц хоол үйлдвэрлэж, үйлчилдэг	1
Хоёр. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлбэр:		
2.1	Бүх боловсруулалтыг хийж хоол үйлдвэрлэн үйлчилдэг	10
2.2	Xагас боловсруулсан бүтээгдэхүүнийг гүйцэд боловсруулан хоол үйлдвэрлэж, үйлчилдэг, урьдчилан бэлтгэсэн хоол, битүүмжлэн савлаагүй бэлэн бүтээгдэхүүнээр үйлчилдэг	5
2.3	Битүүмжлэн савлагдсан, үйлдвэрийн хаяг, шошготой бэлэн бүтээгдэхүүнээр үйлчилдэг	1
Гурав. Хоол хүнсний хэрэглээний тодорхой бүлэгт зориулсан хоол үйлдвэрлэл, үйлчилгээ:		
3.1	Эмнэлэг, сувилал, ахмад настны болон хүүхдийн асрамжийн байгууллага, хүүхдийн зуслан, цэцэрлэг, сургууль, цэргийн анги, хорих газрын хоолны газар	10



Дөрөв. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах ажлын байрны нөхцөл:		
4.1	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах байр нь зориулалтын бус, технологийн ургсгал буруу, түүхий эд хадгалах, бэлтгэх, халуун боловсруулалт хийх болон ажиллагдын хувцас солих өрөө, тасалгаагүй (Хяналтын хуудасны “Гадна орчин, барилга байгууламж” хэсгийн асуултуудын 50 хувьд хангалтгүй гэж үнэлэгдсэн)	10
4.2	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах байр нь зориулалтын бус, засвар үйлчилгээ хийх өөрчилсөн, түүхий эд хадгалах, бэлтгэх, халуун боловсруулалт хийх болон ажиллагдын хувцас солих өрөө, тасалгааг зохион байгуулсан боловч шаардлага хангаагүй (Хяналтын хуудасны “Гадна орчин, барилга байгууламж” хэсгийн асуултуудын 51-70 хувьд хангалттай гэж үнэлэгдсэн)	5
4.3	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах байр нь зориулалтын, технологийн ургсгал зөв, түүхий эд хадгалах агуулах, бэлтгэх өрөө, халуун боловсруулалт хийх өрөө болон ажиллагдын хувцас солих өрөө, тасалгааг шаардлагын дагуу тусад нь зохион байгуулсан (Хяналтын хуудасны “Гадна орчин, барилга байгууламж” хэсгийн асуултуудын 71-ээс дээш хувьд хангалттай гэж үнэлэгдсэн)	1
Тав. Хадгалалтын горимын мөрдөлт хангагдах нөхцөл:		
5.1	Түүхий эд, бүтээгдхүүнийг хадгалах нөхцөл, горимын дагуу хадгандаггүй (ил задгай, эсхүл хадгалах өрөө, агуулахын хэм, чийглэгийг тохицуулж хадгалах боломжгүй, хэм, чийглэгийг хэмждэггүй, амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, зах зээлээс эргүүлэн татсан, хаяг, шошгололт хийж баталгаажуулаагүй бүтээгдэхүүн болон угаалга, ариутгал, цэвэрлэгээний бодистой хамт хадгалдаг)	10
5.2	Түүхий эд, бүтээгдэхүүнийг тусад нь хадгалах өрөө, тасалгааны хүрэлцээ хангалтгүй, түүхий эд, бэлэн бүтээгдэхүүнийг горимын дагуу хадгандаг боловч хэмийг хэмжихиек багаж төхөөрөмжгүй	5
5.3	Түүхий эд, бүтээгдэхүүнийг зохих хэмд хадгалах өрөө тасалгаатай, хөргөлтийн тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан, хэм, чийглэгийг хэмжих тэмдэглэдэг	1
Зургаа. Ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл:		
6.1	Ариутгал, халдвартгүйтгэл, цэвэрлэгээ хийгдэггүй, шавьж, мэрэгч амьтан үүрлэх нөхцөл бүрдсэн	10
6.2	Ариутгал, халдвартгүйтгэл, цэвэрлэгээ тогтмол хийгдэггүй, шавьж, мэрэгч амьтан үүрлэх нөхцөлөөс хамгаалсан боловч хяналт тавьдаггүй	5
6.3	Ариутгал, халдвартгүйтгэлийг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллагаар тогтмол хийлгэдэг, эсхүл тухайн байгууллага зааврын дагуу устгал хийдэг, шавьж, мэрэгч амьтан үүрлэх нөхцөлөөс бүрэн хамгаалсан	1
Долоо. Усан хангамжийн нөхцөл:		
7.1	Усан хангамж нь тодорхой бус, зөвөрний усан хангамжтай, усаа нөөцлөн хэрэглэдэг, усны эрүүл ахуй, аюулгүй байдал (хлорын агууламж, эмгэг төрөгч бичил биетэн гэх мэт)-д шинжилгээ хийлгэдэггүй	10
7.2	Худгаас шугам, хоолойгоор дамжуулан нөөцлөхгүйгээр хоол үйлдвэрлэлд шууд хэрэглэдэг, усны эрүүл ахуй, аюулгүй байдалд шинжилгээ хийлгэдэггүй	5
7.3	Төвлөрсөн усан хангамжтай, усны эрүүл ахуй, аюулгүй байдалд шинжилгээ хийлгэдэггүй	3
7.4	Худгаас шугам, хоолойгоор дамжуулан нөөцлөхгүйгээр хоол үйлдвэрлэлд шууд хэрэглэдэг усны эрүүл ахуй, аюулгүй байдалд шинжилгээ хийлгэдэг	2

7.5	Төвлөрсөн усан хангамжтай, усны эрүүл ахуй, аюулгүй байдалд шинжилгээ хийлгэдэг	1
Найм. Бохир ус, хог хаягдлын нөхцөл:		
8.1	Бохир ус зайлцуулах шугам сүлжээ байхгүй	10
8.2	Бохир ус зайлцуулах хэсгийн шугамд холбогдсон бохирыг тогтмол хугацаанд соруулж зайлцуудаг	5
8.3	Төвлөрсөн бохир ус зайлцуулах шугамд холбогдсон	1
Ес. Хатуу хог хаягдлын нөхцөл:		
9.1	Хог хаягдлын цэггүй	10
9.2	Хог хаягдлын цэгтэй боловч шаардлага хангаагүй	5
9.3	Шаардлага хангасан хог хаягдлын цэгтэй	1
Арав. Хоолны гаралтай хордлого, халдварт өвчин гарсан байдал:		
10.1	Тухайн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт олныг хамарсан хоолны гаралтай хордлого (хордлого, халдварт өвчин үүсгэгч бичил биетнэр бохирдсон), халдварт өвчин давтан гарсан	10
10.2	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт олныг хамарсан хоолны гаралтай хордлого, халдварт өвчин гарсан, өвчин үүсгэгч бичил биетнэр бохирдсон шалтгааныг тодорхойлж арга хэмжээ авдаг	5
10.3	Хоолны гаралтай хордлого, халдварт өвчин гарч байгаагүй, хүнсний гаралтай хордлого, халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж ажилладаг	1
Арван нэг. Өмнө хийсон хяналт шалгалтын талаархи мэдээлэл:		
11.1	Хууль тогтоомжийг ноцтой зөрчсөний улмаас их хэмжээний торгуулийн арга хэмжээ авагдаж байсан, өмнө хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил давтан гардаг, үйл ажиллагааг нь түр хугацаагаар зогсоож байсан	10
11.2	Хууль тогтоомжийг биелүүлж ажиллаагүйн улмаас торгуулийн арга хэмжээ авагдаж байсан, улсын байцаагчийн өгсөн албан шаардлагыг дутуу биелүүлдэг	5
11.3	Хууль тогтоомж, улсын байцаагчийн өгсөн албан шаардлагыг биелүүлж ажилладаг	1
Арван хоёр. Ажиллагсдын эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдсан байдал:		
12.1	Ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, халдварт, паразит өвчлөлийн шинжилгээнд огт хамруулдаггүй	10
12.2	Ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, халдварт, паразит өвчлөлийн шинжилгээнд анх ажилд орсноос хойш дахин давтан хамруулаагүй	5
12.3	Ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, халдварт, паразит өвчлөлийн шинжилгээнд 6 сар тутам хамруулдаг, ажиллагсдын эрүүл мэндийн байдалд өдөр тутам хяналт тавьдаг	1
Арван гурав. Ариун цэвэр, эрүүл ахуйн сургалт явуулдаг байдал:		
13.1	Ажиллагсдыг эрүүл ахуйн зохистой дадал (гар угааж, халдвартгүйгэх, угаалга, цэвэрлэгээ, ариутгал хийх гэх мэт) хэвшүүлэх чиглэлээр сургалтад хамруулдаггүй, байгууллага дотроо эрүүл ахуйн зохистой дадал хэвшүүлэх сургалт зохион байгуулдаггүй	10
13.2	Ажиллагсдыг эрүүл ахуйн зохистой дадал хэвшүүлэх чиглэлээр сургалтад тогтмол хамруулдаггүй, байгууллага дотроо эрүүл ахуйн зохистой дадал хэвшүүлэх сургалт тогтмол зохион байгуулдаггүй	5
13.3	Ажиллагсдыг эрүүл ахуйн зохистой дадал хэвшүүлэх чиглэлээр сургалтад бүрэн хамруулдаг, байгууллага дотроо эрүүл ахуйн зохистой дадал хэвшүүлэх сургалтыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулдаг	1



65-130 оноо авсан хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг этгээд-Их эрсдэлтэй (хоол хүнсний хэрэглээний тодорхой бүлэгт зориулсан хоол үйлдвэрлэдэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага, хууль тогтоомж, дүрэм, журамд тогтоогдсон шалгуур, үзүүлэлт, шаардлагуудыг зөрчсөн)

45-64 оноо авсан хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг этгээд-Дунд эрсдэлтэй (хууль тогтоомж, дүрэм, журамд тогтоогдсон шалгуур, үзүүлэлт, шаардлагуудыг дутуу хангадаг)

45-аас бага оноо авсан хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг этгээд-Бага эрсдэлтэй (хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага, хууль тогтоомж, дүрэм, журамд тогтоогдсон шалгуур, үзүүлэлт, шаардлагуудыг зөрчөөгүй)

### 1.3. ХҮНСНИЙ ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ ЭТГЭЭДИЙГ ЭРСДЭЛИЙН АНГИЛАЛД ХАМААРУУЛАХ ШАЛГУУР, ҮЗҮҮЛЭЛТ

	Шалгуур	Оноо
Нэг. Хүнсний худалдааны байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл:		
1.1	Хүнсний худалдаа явуулах байр нь ариун цэвэр, эрүүл ахуй, технологийн шаардлага хангаагүй, хүнсний бүтээгдэхүүн хадгалах өрөө, тасалгаагүй, худалдаа явуулах байрыг шинээр барих буюу бүрэн засвар хийх шаардлагатай	10
1.2	Хүнсний худалдаа явуулах байр нь ариун цэвэр, эрүүл ахуй, технологийн шаардлага хангасан, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалтын өрөө, тасалгаатай, байранд хэсэгчилсэн засвар үйлчилгээ хийх шаардлагатай	5
1.3	Хүнсний худалдаа явуулах байр нь ариун цэвэр, эрүүл ахуй, технологийн шаардлага хангасан, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалтын өрөө, тасалгаа, агуулахтай	1
Хоёр. Мал, амьтан, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, худалдаалалт:		
2.1	Мал, амьтан, ургамлын гаралтай ангилж савлаагүй хүнсний бүтээгдэхүүн (мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг), далайн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн, түргэн муудаж чанараа алдах бүтээгдэхүүн (кремтэй гурвалан бүтээгдэхүүн)-ийг хадгалах нөхцөл, горимын дагуу хадгалдаггүй (ил задгай, эсхүл хадгалах өрөө, агуулахын хэм, чийглэгийг тохируулж хадгалах боломжгүй, хэм, чийглэгийг хэмждэггүй, амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, зах зээлээс эргүүлэн татсан, хаяг шошголот хийж баталгаажуулагийг бүтээгдэхүүн болон угаалга, ариутгал, цэвэрлэгээний бодистой хамт хадгалдаг)	10
2.2	Жимс, хүнсний ногоо, ангилж савалсан мах, үйлдвэрийн аргаар боловсруулж савлагдсан сүүн бүтээгдэхүүн борлуулдаг, түүхий эд, бүтээгдэхүүнийг хадгалах өрөө хүрэлцээгүй, хэмийг шаардлагатай газар хэмждэггүй, мал, амьтан, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг зохих хэмд хадгалах зориулалтын хөргөх тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаагүй	5
2.3	2.1, 2.2-т зааснаас бусад хүнсний бүтээгдэхүүн борлуулдаг, эсхүл мал, амьтан, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг хадгалах өрөө, тасалгаатай, хөргөлтийн тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан, хэм, чийглэгийг хэмжиж тэмдэглэдэг	1



Гурав. Худалдаалж байгаа бүтээгдэхүүний хаяг, шошгололт:		
3.1	Дахин боловсруулалт хийхгүйгээр хэрэглэх бэлэн хоол, хүнс, хагас боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа, нөхцөлийг заасан хаяг, шошгололтгүй, хадгалах хугацаа хэзэрсон бүтээгдэхүүн борлуулдаг	10
Дөрөв. Түргэн гэмтэж муудах хүнсний бүтээгдэхүүний тээвэрлэлт:		
4.1	Түргэн гэмтэж муудах хүнсний бүтээгдэхүүнийг хадгалалтын горим, зориулалтын дагуу тээвэрлэдэггүй	10
4.2	Түргэн гэмтэж муудах хүнсний бүтээгдэхүүнийг хадгалалтын горим, зориулалтын дагуу тээвэрлэдэг	1
Тав. Ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл:		
5.1	Ариутгал, халдвартгүйтгэл, цэвэрлэгээ хийгдэггүй, шавьж, мэрэгч амьтан үүрлэх нөхцөл бурдсан	10
5.2	Ариутгал, халдвартгүйтгэл, цэвэрлэгээ тогтмол хийгдэггүй, шавьж, мэрэгч амьтан үүрлэх нөхцөлөөс хамгаалсан боловч байнгын хяналт тавьдаггүй	5
5.3	Ариутгал, халдвартгүйтгэлийг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллагаар тогтмол хийлгэдэг, эсхүл тухайн байгууллага зааврын дагуу устгал хийдэг, шавьж, мэрэгч амьтан үүрлэх нөхцөлөөс бүрэн хамгаалсан	1
Зургаа. Ус хангамжийн нөхцөл:		
6.1	Усан хангамж нь тодорхой бус, зөөврийн усан хангамжтай, усаа нөөцлөн хэрэглэдэг	5
6.2	Худаг болон төвлөрсэн усан хангамжтай	1
Долоо. Худалдаалж байгаа хүнсний бүтээгдэхүүнээс хүнсний гаралтай хордлого, халдварт өвчин гарсан байдал:		
7.1	Худалдаалж байгаа бүтээгдэхүүнээс нь олныг хамарсан хүнсний гаралтай хордлого (хордлого, халдварт өвчин үүсгэгч бичил биетнээр бохирдсон), халдварт өвчин давтсан гарсан	10
7.2	Худалдаалж байгаа бүтээгдэхүүнээс нь олныг хамарсан хүнсний гаралтай хордлого, халдварт өвчин гарсан, өвчин үүсгэгч бичил биетнээр бохирдсон шалтгааныг тодорхойлж арга хэмжээ авдаг	5
7.3	Худалдаалж байгаа бүтээгдэхүүнээс нь хүнсний гаралтай хордлого, халдварт өвчин гарч байгаагүй, хүнсний гаралтай хордлого, халдварт өвчин гарахас урьдчилан сэргийлж ажилладаг	1
Найм. Өмнө хийсэн хяналт шалгалтын талаархи мэдээлэл:		
8.1	Хууль тогтоомжийг ноцтой зөрчсөний улмаас их хэмжээний торгуулийн арга хэмжээ авагдаж байсан, өмнө хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил давтсан гардаг, үйл ажиллагааг нь түр хугацаагаар зогсоож байсан	10
8.2	Хууль тогтоомжийг биелүүлж ажиллаагүй улмаас торгуулийн арга хэмжээ авагдаж байсан, улсын байцаагчийн өгсөн албан шаардлагыг дутуу биелүүлдэг	5
8.3	Хууль тогтоомж, улсын байцаагчийн өгсөн албан шаардлагыг биелүүлж ажилладаг	1
Ес. Ажиллагдын эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдсан байдал:		
9.1	Ажиллагдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, халдварт, паразит өвчлөлийн шинжилгээнд отг хамруулдаггүй	10
9.2	Ажиллагдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, халдварт, паразит өвчлөлийн шинжилгээнд анх ажилд орсноос хойш дахин давтсан хамруулаагүй	5
9.3	Ажиллагдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, халдварт, паразит өвчлөлийн шинжилгээнд б 6 сар тутам хамруулдаг, ажиллагдын эрүүл мэндийн байдалд өдөр тутам хяналт тавьдаг	1



55-85 оноо авсан хүнсний худалдаа, үйлчилгээ эрхэлдэг этгээд-Их эрсдэлтэй (эрсдэл ихтэй бүтээгдэхүүнийг ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангаж худалдаалдаггүй, хууль тогтоомж, дүрэм, журамд тогтоогдсон шалгуур, үзүүлэлт, шаардлагуудыг зөрчсэн)

40-54 оноо авсан хүнсний худалдаа, үйлчилгээ эрхэлдэг этгээд-Дунд эрсдэлтэй (ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага, хууль тогтоомж, дүрэм, журамд тогтоогдсон шалгуур, үзүүлэлт, шаардлагуудыг дутуу хангадаг)

40-өөс бага оноо авсан хүнсний худалдаа, үйлчилгээ эрхэлдэг этгээд-Бага эрсдэлтэй (ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага, хууль тогтоомж, дүрэм, журамд тогтоогдсон шалгуур, үзүүлэлт, шаардлагуудыг ханган ажилладаг)

#### 1.4. МАЛ, АМЬТНЫ ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД БҮТЭЭГДЭХҮҮН БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧ ЭТГЭЭДИЙГ ЭРСДЭЛИЙН АНГИЛАЛД ХАМААРУУЛАХ ШАЛГУУР, ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуур		Оноо
Нэг. Үйлдвэрлэлийн хоногийн хүчин чадал:		
1.1	500-гаас дээш толгой мал нядалдаг, 5000-аас дээш шувуу, 500-гаас дээш гахай эсхүл үхэр, адуу, тэмээний аж ахуй эрхэлдэг, 700-гаас дээш гогцоо өлөн гэдэс үйлдвэрлэдэг, 1000-аас дээш бог, 200-гаас дээш бодын арьс, шир боловсруулдаг, агуулахуд	10
1.2	300-500 толгой мал нядалдаг, 2000-5000 шувуу, 200-500 гахай тэжээдэг, 200-700 гогцоо өлөн гэдэс үйлдвэрлэдэг, 200-1000 бог, 70-200 бодын арьс, шир боловсруулдаг	7
1.3	300-гаас доош толгой мал нядалдаг, 2000-аас доош шувуу, 200-гаас доош гахай эсхүл жижиг амьтад тэжээдэг, 200-гаас доош өлөн гэдэс үйлдвэрлэдэг, 200-гаас доош бог, 70-аас доош бодын арьс, шир боловсруулдаг	3
Хоёр. Үйлдвэрлэлийн ажлын байрны нөхцөл:		
2.1	Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулах байр нь зориулалтын бус, шаардлага хангагүй	10
2.2	Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулах байр нь зориулалтын бус боловч засвар үйлчилгээ хийж өөрчилсөн, түүхий эд хадгалах, бэлтгэх, боловсруулалт хийх болон ажиллагсдын хувцас солих өрөө, тасалгаатай боловч шаардлагыг бүрэн хангагүй	5
2.3	Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулах байр нь зориулалтын, шаардлага хангасан	1
Гурав. Хадгалаалтын горимын нөхцөл хангасан байдал:		
3.1	Түүхий эд, бэлэн бүтээгдэхүүн, сав, баглаа, боодлыг тусгаарлан хадгалах нөхцөл, горимын дагуу хадгалдаггүй	10
3.2	Түүхий эд, бэлэн бүтээгдэхүүн, сав, баглаа, боодлыг зохих хэмд тусгаарлан хадгалах өрөө, тасалгаатай, хөргөлтийн тоног төхөөрөмжкөө бүрэн хангагдсан, хэм, чийглэгийг хэмжиж тэмдэглэдэг, амьттан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, зах зээлээс эргүүлэн татсан, хаяг, шошголт хийж баталгаажуулаагүй бүтээгдэхүүн болон угаалга, ариутгал, цэвэрлэгээний бодистой хамт хадгалдаггүй	1



Дөрөв. Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг мал эмнэлэг, ариун цэврийн шинжилгээнд хамруулсан байдал:

4.1	Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг мал эмнэлэг, ариун цэврийн хөндлөнгийн шинжилгээнд хамруулдаггүй, дээжийг шинжилгээнд хамруулдаг боловч аюулгүйн үзүүлэлтүүд зөвшөөрөгдхөд дээд хэмжээнээс хэтэрсэн	10
4.2	Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг мал эмнэлэг, ариун цэврийн хөндлөнгийн шинжилгээнд хамруулж хэвшсэн, аюулгүйн үзүүлэлтүүд зөвшөөрөгдхөд дээд хэмжээнд буюу түүнээс доош	1

Тав. Эрүүл ахуйн нөхцөл:

5.1	Ариутгал, халдвартгүйтгэл, цэвэрлэгээ хийгдэггүй, шавьж, мэрэгч амьтан үүрлэх нөхцөл бурдсан	10
5.2	Ариутгал, халдвартгүйтгэл, цэвэрлэгээ тогтмол хийгдэггүй, шавьж, мэрэгч амьтан үүрлэх нөхцөлөөс хамгаалсан боловч хяналт тавьдаггүй	5
5.3	Ариутгал, халдвартгүйтгэлийг мэргэжлийн байгууллагаар гэрээгээр тогтмол хийгдэдэг, шавьж, мэрэгч амьтан үүрлэх нөхцөлөөс бүрэн хамгаалсан	1

Зургаа. Усан хангамжийн нөхцөл:

6.1	Усан хангамж нь тодорхой бус, зөввэрийн усан хангамжтай, усаа нөөцлөн хэрэглэдэг, усны эрүүл ахуй, аюулгүй байдал (хлорын агууламж, эмгэг төрөгч бичил биетэн гэх мэт)-д шинжилгээ хийгдэггүй	10
6.2	Худгаас шугам, хоолойгоор дамжуулан нөөцлөхгүйгээр үйлдвэрлэлд шууд хэрэглэдэг, усны эрүүл ахуй, аюулгүй байдалд шинжилгээ хийгдэггүй	5
6.3	Худгаас шугам, хоолойгоор дамжуулан нөөцлөхгүйгээр үйлдвэрлэлд шууд хэрэглэдэг, усны эрүүл ахуй, аюулгүй байдалд шинжилгээ хийгдэдэг эсхүл төвлөрсөн усан хангамжтай	1

Долоо. Бохир ус зайлцуулах нөхцөл:

7.1	Бохир ус зайлцуулах шугам сүлжээ байхгүй	10
7.2	Бохир ус зайлцуулах хэсгийн шугамд холбогдсон, бохирыг тогтмол хугацаанд соруулж зайлцуулдаг	5
7.3	Төвлөрсөн бохир ус зайлцуулах шугамд холбогдсон, арьс шир, түүхий эдээс ялгарсан илүүдэл шүүс, угаалга, цэвэрлэгээний шингэнийг гадагшуулах суваагтай, шүүс, шингэн хог хаягдлыг цуглуваж ариутгах зориулалттай бетон доторлогогоотой худаг эсхүл төмөр савтай	1

Найм. Хатуу хог хаягдлын нөхцөл:

8.1	Хог хаягдлын цэг нь шаардлага хангагүй, өвчтэй мал, амьтны түүхий эд, бүтээгдэхүүнийг устгах цэгтэй	10
8.2	Хог хаягдлыг тогтмол ачуулдаггүй, өвчтэй мал, амьтны түүхий эд, бүтээгдэхүүнийг нүхэнд булж устгадаг	5
8.3	Шаардлага хангасан хог хаягдлын цэгтэй, өвчтэй мал, амьтны түүхий эд, бүтээгдэхүүнийг шатаах зуух хэрэглэж, устгадаг	1

Ес. Хордлого, халдварт өвчин гарсан байдал:

9.1	Үйлдвэрлэж, бэлтгэн нийлүүлсэн түүхий эд, бүтээгдэхүүнээс нь мал, амьтны гаралтай халдварт өвчин, олныг хамарсан хүнсний гаралтай хордлого гарсан, бүтээгдэхүүн нь өвчин үүсгэгч бичил биетнэр бахирдсон шалтгааныг тодорхойлж, арга хэмжээ авдаг	10
9.2	Үйлдвэрлэж, бэлтгэн нийлүүлсэн түүхий эд, бүтээгдэхүүнээс нь мал, амьтны гаралтай халдварт өвчин, олныг хамарсан хүнсний гаралтай хордлого гарсан, бүтээгдэхүүн нь өвчин үүсгэгч бичил биетнэр бахирдсон шалтгааныг тодорхойлж, арга хэмжээ авдаг	5



9.3	Үйлдвэрлэж, бэлтгэн нийлүүлсэн түүхий эд, бүтээгдэхүүнээс нь мал, амьтны гаралтай халдварт өвчин, олын хамарсан хүнсний гаралтай хордлого гарч байгаагүй, хүнсний гаралтай хордлого, халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж ажилладаг	1
<b>Арав. Өмнө хийсэн хяналт шалгалтын талаархи мэдээлэл:</b>		
10.1	Хууль тогтоомж, шаардлагыг зөрчсөнний улмаас арга хэмжээ авагдаж байсан, өмнө хийсэн шалгалтаар илрэсэн зөрчил давтагдан гардаг, зөрчлийг бууруулах арга хэмжээ авдаггүй	10
10.2	Хууль тогтоомж, шаардлагыг биелүүлж ажиллаагүйн улмаас арга хэмжээ авагдаж байсан, зөрчлийг бууруулах арга хэмжээ авч ажилладаг, хууль тогтоомж, стандартын шаардлагыг бүрэн биелүүлээгүй	5
10.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1
<b>Арван нэг. Мал эмнэлэг, ариун цэврийн чиглэлээр сургалт явуулдаг байдал:</b>		
11.1	Ажиллагсдыг мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн зохистой дадал (малаас хунд дамжин халдвартладаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, гар угааж, халдвартгүйтгэх, угаалга, цэвэрлэгээ, ариутгал хийх гэх мэт) хэвшүүлэх чиглэлээр сургалтад хамруулдаггүй, дотооддоо эрүүл ахуйн зохистой дадал хэвшүүлэх сургалтыг зохион байгуулдаггүй	10
11.2	Ажиллагсдыг мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн зохистой дадал хэвшүүлэх чиглэлээр сургалтад тогтмол хамруулдаггүй	5
11.3	Ажиллагсдыг мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн зохистой дадал хэвшүүлэх чиглэлээр сургалтад бүрэн хамруулдаг, дотооддоо эрүүл ахуйн зохистой дадал хэвшүүлэх сургалтыг зохион байгуулж тогтмолжсон	1
<b>Арван хоёр. Лаборатори:</b>		
12.1	Дотоод хяналтын лабораторигүй, малын эмчгүй, хөндлөнгийн хяналтад тогтоосон хугацаанд хамрагддаггүй	10
12.2	Дотоод хяналтын лабораторигүй, малын эмчгүй, хөндлөнгийн хяналтад тогтоосон хугацаанд хамрагддаг	8
12.3	Дотоод хяналтын лабораторитой, малын эмчтэй, хөндлөнгийн хяналтад тогтоосон хугацаанд хамрагддаггүй	8
12.4	Дотоод хяналтын лабораторитой, малын эмчтэй, хөндлөнгийн хяналтад тогтоосон хугацаанд хамрагддаг	1

Агуулахыг 6, 7, 11, 12-р шалгуураас бусад шалгуураар үзүүлнэ.

60-120 оноо авсан бол (агуулах 40-80 оноо)-Их эрсдэлтэй (эрсдэл ихтэй үйл ажиллагаа эрхэлдэг, хүчин чадал ихтэй, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага, хууль тогтоомж, дүрэм, журамд тогтоогдсон шалгуур, үзүүлэлт, шаардлагуудыг зөрчсөн)

40-59 оноо авсан бол (агуулах 24-39 оноо)-Дунд эрсдэлтэй (ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага, хууль тогтоомж, дүрэм, журамд тогтоогдсон шалгуур, үзүүлэлт, шаардлагуудыг дутуу хангадаг)

40-өөс бага оноо авсан бол (агуулах 23-аас бага)-Бага эрсдэлтэй (үйлдвэрийн цар хэмжээ бага, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага, хууль тогтоомж, дүрэм, журамд тогтоогдсон шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг зөрчөөгүй)



**1.5. УРГАМЛЫН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮН  
БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧ ЭТГЭЭДИЙГ ЭРСДЭЛИЙН  
АНГИЛАЛД ХАМААРУУЛАХ ШАЛГУУР, ҮЗҮҮЛЭЛТ**

Шалгур	Оноо
Нэг. Тариалдаг болон хадгалдаг таримлын төрөл:	
1.1 Түргэн гэмтэж мууддаг хүнсний ногоо, жимс жимсгэнэ (навчт ногоо, цэцтгэлт байцаа, лооль, хэмх, мөөг, гадил, усан үзэм, үхрийн нүд, чацарагна гэх мэт)	10
1.2 Төмс, хүнсний ногоо (байцаа, манжин, лууван, сонгино, сармис гэх мэт)	5
1.3 Үр тарианы таримал (буудай, арвай, хөх тариа, бог будаа гэх мэт )	1
Хоёр. Талбайн хэмжээ:	
2.1 500 га-гаас дээш талбай, 500 тонноос дээш зоорь, агуулах	10
2.2 11-500 га талбай, 100-500 тонн зоорь, агуулах	5
2.3 1-10 га талбай, 100 тонноос доош зоорь, агуулах	1
Гурав. Бүтээгдэхүүн, химиийн бодис, бордооны дээжийг шинжилгээнд хамруулсан байдал:	
3.1 Бүтээгдэхүүн, химиийн бодис, бордооны дээжийг шинжилгээнд хамруулдаггүй	10
3.2 Бүтээгдэхүүн, химиийн бодис, бордооны дээжийг шинжилгээнд хамруулдаг боловч аюулгүйн үзүүлэлтүүд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсон	8
3.3 Бүтээгдэхүүн, химиийн бодис, бордооны дээжийг шинжилгээнд хамруулж хөвшсэн, аюулгүйн үзүүлэлтүүд зөвшөөрөгдөх дээд хэмжээнд буюу түүнээс доош	1
Дөрөв. Хадгалалтын горимын мөрдөлт хангагдах нөхцөл:	
4.1 Бүтээгдэхүүнийг горимын дагуу хадгалдаггүй	10
4.2 Бүтээгдэхүүнийг горимын дагуу хадгалдаг боловч хэм, чийг хэмжих зориулалтын багаж төхөөрөмжгүй, агааржуулалтын системийн ажиллагаа хангалтгүй	5
4.3 Бүтээгдэхүүн болон химиийн бодис, бордоог зориулалтын агуулах, зооринд хадгалдаг, хэмжигч бараж, агааржуулалтын систем хэвийн ажилладаг, хэм, чийглэгийг хэмжиж тэмдэглэдэг	1
Тав. Гадна талбай:	
5.1 Агуулах, зоорины гадна талбай болон үтрээнийн талбайг хусаж цэвэрлээгүй, цардаж бэлтгээгүй	10
5.2 Агуулах, зоорины гадна талбай болон үтрээнийн талбайг тохижуулсан боловч хүчин чадалдаа тохирохгүй	5
5.3 Агуулах, зоорины гадна талбай болон үтрээнийн талбай нь хүчин чадалдаа тохирсон, хусаж цэвэрлэсэн, цардаж бэлтгэсэн	1
Зургаа. Ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл:	
6.1 Ариутгал, халдвартгүйтгэл, цэвэрлэгээ хийгдээгүй, шавьж, мэрэгч амьтан үүрлэх нөхцөл бүрдсэн (онгорхой, цоорхой, битүүмжлэл мүү)	10
6.2 Ариутгал, халдвартгүйтгэл, цэвэрлэгээ тогтмол хийгдээгүй, шавьж, мэрэгч амьтан үүрлэх нөхцөлөөс хамгаалсан боловч хяналт тавьдаггүй	5
6.3 Ариутгал, халдвартгүйтгэлийг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллагаар тогтмол хийлгэдэг, эсхүл тухайн байгууллага зааврын дагуу устгал хийдэг, шавьж, мэрэгч амьтан үүрлэх нөхцөлөөс бүрэн хамгаалсан	1
Долоо. Хүнсний гаралтай хордлого, халдварт өвчин гарсан байдал:	
7.1 Бүтээгдэхүүнээс нь оныг хамарсан хүнсний гаралтай хордлого, халдварт өвчин давтан гарсан, ургамлын хортон шавьж, хог ургамлын үрээр бохирдсон бөгөөд түүнийг дамжуулсан	10



7.2	Бүтээгдэхүүнээс нь олныг хамарсан хүнсний гаралтай хордлого, халдварт өвчин гарсан, ургамлын хортон шавьж, хог ургамлын үрээр бохирдсон шалтгааныг тодорхойлж арга хэмжээ авдаг	5
7.3	Бүтээгдэхүүнээс нь олныг хамарсан хүнсний гаралтай хордлого, халдварт өвчин гарч байгаагүй, ургамлын хортон шавьж, хог ургамлын үрээр бохирдох бөгөөд түүнийг дамжуулахаас урьдчилан сэргийлж ажилладаг	1
Найм. Түргэн гэмтэж, муудах хүнсний бүтээгдэхүүний тээвэрлэлт:		
8.1	Түүхий эд, бүтээгдэхүүнийг хадгалалтын горим, зориулалтын дагуу тээвэрлэдэггүй	10
8.2	Түүхий эд, бүтээгдэхүүнийг хадгалалтын горим, зориулалтын дагуу тээвэрлэдэг	1
Ес. Боловсон хүчний хангамж:		
9.1	Мэргэжлийн агрономич, мэргэшсэн ажилтангүй	10
9.2	Мэргэжлийн агрономич, мэргэшсэн ажилтантай	1
Арав. Өмнө хийсэн хяналт шалгалтын талаархи мэдээлэл:		
10.1	Хууль тогтоомж, шаардлагыг зөрчсөний улмаас арга хэмжээ авагдаж байсан, өмнө хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил давтагдан гардаг, зөрчлийг бууруулах арга хэмжээ авдаггүй	10
10.2	Хууль тогтоомж, шаардлагыг биелүүлж ажиллаагүйн улмаас арга хэмжээ авагдаж байсан, зөрчлийг бууруулах арга хэмжээ авч ажилладаг, хууль тогтоомж, стандартын шаардлагыг бүрэн биелүүлэггүй	5
10.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1

50-100 оноо авсан бол-Их эрсдэлтэй (түргэн гэмтэж муудах бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлдэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага, хууль тогтоомж, дүрэм, журамд тогтоогдсон шалгуур, үзүүлэлт, шаардлагуудыг зөрчсөн)

30-49 оноо авсан бол-Дунд эрсдэлтэй (ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага, хууль тогтоомж, дүрэм, журамд тогтоогдсон шалгуур, үзүүлэлт, шаардлагуудыг дутуу хангадаг)

30-аас бага оноо авсан бол-Бага эрсдэлтэй (ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага, хууль тогтоомж, дүрэм, журамд тогтоогдсон шалгуур, үзүүлэлт, шаардлагуудыг зөрчөөгүй)

## 1.6. ИМПОРТЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ЭРСДЭЛИЙН АНГИЛАЛД ХАМААРУУЛАХ ШАЛГУУР, ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуур		Оноо
Нэг. Бодис, бараа, бүтээгдэхүүний төрөл:		
1.1	Мал, амьтан, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, амьд мал, хүнсний боловсруулсан бүтээгдэхүүн, хүнсний нэмэлт, химиин хорт болон аюултай бодис, химиийн үйлдвэрийн түүхий эд, бүтээгдэхүүн, эм, эмнэлгийн хэргэсэл, биологийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн (нян өсгөөр, цус, цусны ийлдэс, донорын эд эрхтэн, омог, вакцин, арчдас, шээс, шүлс гэх мат), шарил, чандар, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, хүүхдийн тоглоом, барилгын материал	10
1.2	Хуучин хувцас, цахилгаан бараа, ашигт малтмал, эрдэс, газрын тос, геологийн бүтээгдэхүүн, ахуйн химиин бүтээгдэхүүн	5
1.3	Бусад	1



Хоёр. Олон улсад шуурхай болон тогтмол мэдээлэх хүн, малын халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйлсийн төлөв байдал, цацраг, химиин хорт бодисын бохирдолттой улс, бус нутгаас импортлогдсон эсэх:

2.1	Халдварт өвчин бүртгэгдсэн, ургамлын хорио цээртэй зүйлс тархсан, цацраг, химиин хорт бодисын бохирдолттой улс, бүсээс	10
2.2	Халдварт өвчин бүртгэгдсэн, ургамлын хорио цээртэй зүйлс тархсан, цацраг, химиин хорт бодисын бохирдолттой улстай хил залгаа улс, бүсээс	5
2.3	Халдварт өвчин бүртгэгдээгүй, ургамлын хорио цээртэй зүйлс тархаагүй, цацраг, химиин хорт бодисын бохирдолтгүй улс, бүсээс	1

Гурав. Тээвэрлэлтийн байдал:

3.1	Хэд хэдэн улсын нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэгдэх	10
3.2	Нэг улсын нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэгдэх	5
3.3	Шууд тээвэрлэгдэх	1

Дөрөв. Тээвэрлэлтийн нөхцөл:

4.1	Зориулалтын тээврийн хэрэгсэл шаардагддаг	10
4.2	Зориулалтын тээврийн хэрэгсэл шаардагддаггүй	1

Тав. Боловсруулсан, үйлдвэрлэсэн байдал:

5.1	Боловсруулаагүй, түүхий эд хэлбэртэй	10
5.2	Хагас боловсруулсан	7
5.3	Боловсруулсан, үйлдвэрлэсэн, бэлэн бүтээгдэхүүн	3

Зургаа. Зориулалт:

6.1	Үйлдвэрлэлийн	10
6.2	Хүнсний	10
6.3	Эмчилгээ, сувилгааны	10
6.4	Судалгаа, шинжилгээний	7
6.5	Худалдаа, үйлчилгээний	7
6.6	Үзэсгэлэн, сурталчилгааны	5
6.7	Бусад	1

Долоо. Савлагаа:

7.1	Задгай	10
7.2	Зориулалтын бус савлагаатай	5
7.3	Зориулалтын савлагаатай	1

Найм. Хордлого, халдварт өвчин гарсан байдал:

8.1	Бүтээгдэхүүнээс нь хүн, мал, амьтны хөл хориот, гоц халдварт өвчин, олныг хамарсан хордлого гарсан	10
8.3	Бүтээгдэхүүнээс нь мал, амьтны гаралтай гоц халдварт өвчин, олныг хамарсан хордлого, халдварт өвчин бүртгэгдээгүй	1

48-80 оноо авсан импортын мал амьтан, ургамал, түүхий эд, бодис бараа, бүтээгдэхүүн-Их эрсдэлтэй тул импортлохын өмнөх эрсдэлийг бууруулах хяналт, баримт бичгийн хяналт, тээврийн хэрэгслийн хяналт, лабораторийн шинжилгээнд хамруулах

24-47 оноо авсан импортын мал амьтан, ургамал, түүхий эд, бодис бараа, бүтээгдэхүүн-Дунд эрсдэлтэй тул баримт бичгийн хяналт, тээврийн хэрэгслийн хяналт, шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээнд хамруулах

23-аас бага оноо авсан импортын мал амьтан, ургамал, түүхий эд, бодис бараа, бүтээгдэхүүн-Бага эрсдэлтэй тул баримт бичгийн хяналт, тээврийн хэрэгслийн хяналт, лабораторийн шинжилгээнд хамруулахгүй.



**2.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ОБЪЕКТЫГ  
ЭРСДЭЛИЙН АНГИЛАЛД ХАМААРУУЛАХ ШАЛГУУР, ҮЗҮҮЛЭЛТ**

Шалгур		Оноо
Нэг. Үйл ажиллагааны нарийн төвөгтэй шинж байдал:		
1.1	Үйл ажиллагаанаас шалтгаалж тухайн орчинд узүүлэх нөлөөлөл: 1.1.1 Агаар-хөрс-усыг зэрэг бохирдуулах аюултай 1.1.2 Агаар-хөрс, хөрс-ус эсхүл агаар-ус бохирдуулах аюултай 1.1.3 Аль нэгийг нь илүү бохирдуулах аюултай 1.1.4 Алийг нь ч бохирдуулахгүй	10 10 5 1
1.2	Үйлдвэрлэлийн газарт явагдаж байгаа үйл ажиллагаа: 1.2.1 Үйлдвэрлэлийн үйл ажиллагаандaa тэсэрч дэлбэрэх болон А зэрэглэлийн химийн хортой болон аюултай бодис ашигладаг (цианит, натри, хром, мөнгөн ус, хүчил, шүлт гэх мэт) 1.2.2 Хор аюул баатай бодис ашигладаг (угаалгын бодис, будагч бодис гэх мэт) 1.2.3 Байгалийн нөөц баялаг ашигладаг (ус, рашаан, ой, ургамал, ан амьтан, нүүрс, элс хайрга, шавар гэх мэт) 1.2.4 Бусад (Байгалиас бэлтгэсэн нөөц баялагийг боловсруулдаг, байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулдаг гэх мэт)	10 7 5 0
1.3	Үйл ажиллагаанаас гарахаа бохирдол, хог хаягдал: 1.3.1 Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад химийн бодисын хольцтой шингэн, хатуу, аюултай хог хаягдал гаргадаг 1.3.2 Үйлдвэрлэлийн хог хаягдал гаргадаг 1.3.3 Ахуйн хог хаягдал гаргадаг	10 5 1
Хоёр. Үйл ажиллагааны явцад ялгаруулах хий, бохирдол		
2.1	Үйлдвэрлээс гарсан хог хаягдлын хэмжээ: 2.1.1 Хоногт гаргаж байгаа хог хаягдал нь 100 м <sup>3</sup> -ээс дээш 2.1.2 Хоногт гаргаж байгаа хог хаягдал нь 100 м <sup>3</sup> -ээс доош 2.1.3 Үйлдвэрлэлийн хог хаягдал гаргадаггүй	10 5 1
2.2	Хог хаягдлын боловсруулалт: 2.2.1 Хог хаягдаа дахин боловсруулдаггүй, ангилан ялгадаггүй 2.2.2 Хог хаягдаа дахин боловсруулдаг, ангилан ялгадаг	5 1
